

**“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

I. ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Компани 2021 онд 14 төсөвт байгууллага, 96 аж ахуйн нэгж, 1107 айл өрх, нийт 1217 хэрэглэгчтэй дулааны эрчим хүч, цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулах гэрээ байгуулан ажилласан.

1. Дулааны эрчим хүч

Тайлант онд 38.05 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 38.8 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн 102 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зуны улирал буюу 5 сарын 15-ны өдрөөс 9 сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд 1 зуух галлан орон сууцны хэрэглэгчдийг хэрэгцээний халуун усаар тасралтгүй ханган ажилласан.

Сүлжээний нэмэлт усны зарцуулалт төлөвлөгөөнөөс 6.8 мян.м³-ээр буурч 19.3мян.м³ гарсан байна. Усны алдагдалтай холбоотой дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан, шугам сүлжээнд гарсан гэмтлийг шуурхай устгаж, түгээх шугамын шинэчлэлийн ажлыг үе шаттай хийж байгаа зэргээс шалтгаалан нэмэлт усны алдагдал багассан. Мөн хуучин тосгоны 2 давхар байрууд нь хэрэгцээний халуун усны шугамгүй учир хэрэглэгчид сүлжээний усыг зүй бусаар ашиглаж нэмэлт усны зарцуулалтыг ихэсгэдэг байдалд хяналт тавьж хэрэглэгчдээр эргэлт, ухуулга сурталчилгаа хийх, системд тавьсан крантыг авч заглушка тавих зэрэг ажил зохион байгуулан ажилласан. Сүлжээний нэмэлт усны цагийн дундаж зарцуулалт 2.2м³/ц болон өмнөх оныхоос 4,3 хувиар буурсан. Үүнтэй уялдан 23.3 тонн технологийн давс хэрэглэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 17.8 тонн давс хэрэглэж, 5.5 тонн давсыг хэмнэсэн буюу давсны хэрэглээ 23.6 хувиар буурсан байна.

2. Ус хангамж, ариутгал татуурга

351.7 мян.м³ ус олборлохоос 306.8 мян.м³ус олборлон 87.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь тоолууржилт болон хэрэглэгчдийн усны зохистой хэрэглээ бий болж байгаагаас ус олборлолт буурсан.

Одоогийн байдлаар төсвийн байгууллага 100 хувь, бусад аж ахуй нэгж 97 хувь, айл өрхийн 92 хувь нь усны тоолуураар тооцоо хийж байна. 2021 онд 23 айл өрхөд 38 ширхэг тоолуурыг шинээр суурилуулсан.

309.3 мян.м³ бохир ус татан зайлуулахаас гүйцэтгэлээр 251.6мян.м³ бохир усыг татан зайлуулсан.

Үндсэн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг мөн үетэй харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

№	Нэр	Хэмжихн эгж	2020.12.31	2021.12.31		зөрүү	
			гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос	төлөвлөгөөнөөс
1	Үйлдвэрлэсэн ДЭХ	мян.Гкал	38.86	38.05	38.81	-0.05	0.76
2	Дотоод хэрэглээ	мян.Гкал	3.2	3.2	3.2	-	-
3	Түгээсэн ДЭХ	мян.Гкал	35.66	34.85	35.61	-0.05	0.76
4	Нүүрс	мян.тн	13.96	13.5	13.98	0.02	0.48
5	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/гкал	193.5	201.7	196.0	2.5	-5.7
6	Нэмэлт ус	мян.тн	19.96	26.1	19.3	-0.66	-6.8
7	Давс	мян.тн	17.6	23.3	17.8	0.2	-5.5
8	Цэвэр ус	мян.тн	320.0	351.7	306.8	-13.2	-44.9
9	ЦЭХ-ний хэрэглээ	мян.кВт	2 176.1	2 259.2	2 266.1	90.0	6.9

Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд тайлант онд 2 259.1 мян.кВт цахилгаан эрчим хүч хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2 266.1 мян.кВт цахилгаан эрчим хүч хэрэглэсэн. Үндсэн үйлдвэрлэлийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ төлөвлөгөөнөөс 8 280 кВт-аар буурсан боловч гэр хороололд ус түгээх 8 худгийг 24 цагийн автомат ажиллагаанд оруулсан, мөн халаалтын улиралд галладаг байсныг цахилгаан халаагуурт шилжүүлсэнтэй холбоотой худгуудын цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж төлөвлөгөөнөөс 7.0 мян.кВт хэтэрсэн үзүүлэлттэй гарсан байна.

Хэрэглэгчдээс нийт 1 307 дуудлага хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан. Дуудлагын тоо өмнөх оноос 311 буюу 19.2 хувиар буурсан байна. Засварын ажил үйлчилгээний орлого 2 749.1 мян төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Дуудлагыг төрлөөр нь ангилбал:


Дуудлагын төрөл	х.н	Халаалт	Хэрэгцээний халуун ус	Цэвэр ус	Бохир ус	Тоолуур	Бусад	Бүгд
2020 он	тоо	261	120	317	332	212	378	1 620
2021 он	тоо	240	93	303	293	49	307	1 309

II. САНХҮҮГИЙН ТАЛААР

Тайлант онд 3,059.9 сая төгрөгийн борлуулалт орлого хийхээр төлөвлөн 3,032.1 сая төгрөгөөр борлуулалт орлого хийж 99.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Эрчим хүчний алдагдлын татаас 447.0 сая төгрөгийн санхүүжилт авч, зардлыг 433.2 сая төгрөгөөр хэмнэн, 184.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөгөөт алдагдлыг 68.7 хувиар бууруулан ажилласан.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Нийт зардал	3,650.0	3,216.8	(433.2)	88.1
Нийт орлого	3,059.9	3,032.1	(27.8)	99.1
Үүнээс: Үндсэн үйл ажиллагаа	2,484.7	2,384.8	(99.9)	96.0
Үндсэн бус үйл ажиллагаа	128.1	200.3	72.2	156.3
Санхүүжилт	447.1	447.0	(0.1)	100
Алдагдал	(590.1)	(184.7)	405.4	68.7
БО-ын 1 төгрөгт ногдох зардал	1.46	1.34	0.12	8.2

Санхүүгийн үзүүлэлтийг графикаар харуулбал:




Үндсэн үйлдвэрлэлээс 2,484.7 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр 2,384.8 сая төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын төлөвлөгөөг 96.0 хувиар биелүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын задаргаа.

Бүтээгдэхүүн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2021 оны	
			Төлөв-өөс	хувь
Цэвэр ус	173.9	184.7	10.8	106.2
Бохир ус	137.1	157.1	20.0	114.5
Хэрэгцээний халуун ус	99.7	119.4	19.7	119.8
Халаалт	2,074.0	1,923.6	(150.4)	92.7
Үндсэн үйл ажиллагааны орлого	2,484.7	2,384.8	(99.9)	96.0

Борлуулалтын төлөвлөгөөгөөр 173.9 сая төгрөгийн цэвэр ус борлуулахаас 184.7 сая төгрөг буюу 106.2 хувь, 137.1 сая төгрөгийн бохир ус татан зайлуулахаар төлөвлөснөөс 157.1 сая төгрөг буюу 114.5 хувь, 2,074.0 сая төгрөгийн дулааны эрчим хүчний борлуулалт хийхээс 1,923.6 сая төгрөг буюу 92.7 хувь, 99.7 сая төгрөгийн хэрэгцээний халуун усны борлуулалт төлөвлөснөөс 119.4 сая төгрөг буюу 119.8 хувь тус тус биелүүлжээ.

Борлуулалтад эзлэх хувийн жинг графикаар харуулав



Борлуулалт дутуу хийгдсэн шалтгаан:

Үндсэн үйл ажиллагааны борлуулалт төлөвлөгөөнөөс 99.9 сая төгрөгөөр дутуу орсон ба цэвэр бохир усны борлуулалт 50.5 сая төгрөгөөр давж дулааны эрчим хүчний борлуулалт 150.4 сая төгрөгөөр буурсан байна.

- Гадна агаарын хэм өнгөрсөн үеийн мөн үеэс 2-8 градусаар дулаан байснаас шалтгаалан ШГХК –ийн дулаан төлөвлөгөөнөөс 1455.3 гкалаар дутуу хэрэглэж 39.0 сая төгрөгөөр

- ЭХЗХ-оос 2020 оны 01-р сараас төсвийн хэмжүүртэй хэрэглэгчдийн дулааны тариф 30 хувиар нэмэгдсэн тогтоолын төсөл гарсны дагуу төсвийн тоолууртай хэрэглэгчдийн дулааныг нэмэгдүүлж төлөвлөсөн боловч Засгийн газраас дулаан, цэвэр, бохир усны төлбөрийг хөнгөлөх болсноор тариф нэмэгдүүлэхгүй шийдвэр гарснаар төсвийн борлуулалт 130.2 сая төгрөгөөр тус тус буурсан.

- 11 дүгээр сард дулааны эрчим хүчний тарифт өөрчлөлт оруулж, ахуйн хэрэглээний халаалт төлөвлөгөөнөөс 14.6 сая төгрөгөөр, мөн шинээр 11 өрх гэрээ хийж халаалт авснаар 4.2 сая төгрөг, нийт ахуйн хэрэглээний борлуулалт 18.8 сая төгрөгөөр давсан үзүүлэлттэй байна.

Үндсэн бус үйл ажиллагаанаас 128.1 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр 200.3 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлж 72.2 сая төгрөгөөр давуулсан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
Дулааны суурь хураамж	41.4	42.5	1.1
Цэвэр, бохир усны суурь хураамж	43.6	44.6	1.0
Туслах аж ахуйн орлого	16.7	42.9	26.2
Засвар, ажил үйлчилгээ	26.4	109.7	83.3
Дүн	128.1	200.3	72.2

Засвар үйлчилгээний 109.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс 15.9 сая төгрөг нь ШГХК-д хийсэн ажлын хөлс, 93.8 сая төгрөг нь засвар, ажил үйлчилгээ, бусад орлого байна.

- ОРЛОГО

Нийт 2,384.8 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлэхээс 2,304.2 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлж 80.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлэн 96.6 хувийн биелэлттэй байна.

Бүтээгдэхүүн	Борлуулалт	Орлого	зөрүү	хувь
Цэвэр ус	184.7	160.7	-24.0	87.0
Бохир ус	157.1	155.1	-2.0	98.7
Хэрэгцээний халуун ус	119.4	102.7	-16.7	86.0
Халаалт	1,923.6	1,885.7	-37.9	98.0
ДҮН	2,384.8	2,304.2	-80.6	96.6

- ЗАРДАЛ

Тайлант онд нийт 3,650.0 сая төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,216.8 сая төгрөгийн зардал гарч 433.2 сая төгрөг буюу 11.9 хувиар хэмнэлт гарган ажилласан. Нийт зардлын 36.7 хувийг цалин НДШ, 9.4 хувийг цахилгааны зардал, 18.3 хувийг нүүрсний зардал, 13.0 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 1.4 хувийг хөдөлмөр хамгааллын зардал, 5.3 хувийг удирдлага ТУЗ-ийн зардал, 15.9 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Зардлын хэмнэлтийн талаар

Цалингийн зардал Дутуу орон тоог царцаан хавсран ажиллуулж хэмнэлт гарган ажилласан.

Цахилгааны зардал 8.2 сая төгрөгийн цахилгааны хэмнэлт гаргасан. ЭХЗХ-ны 2020 оны 10-р сарын 01-ний 469 тоот тогтоолоор 2021 оны 1-3 саруудад 143.4 сая төгрөгийн цахилгааны зардлыг тарифын хөнгөлөлтөнд хамрагдсан.

Албан томилолтын зардал Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан 6.9 сая төгрөгийн томилолтын зардлыг зарцуулаагүй.

Нүүрс 307.8 тн буюу 13.7 сая төгрөгийн нүүрсний хэмнэлт гаргасан.

Хөдөлмөр хамгаалал 34.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Ковидын зардлын хэмнэлт, ажлын хувцасны үнийн дүнгийн зөрүүнээс хэмнэлт гарсан.

Бусдаар гүйцэтгүүлэх зардал 21.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь горим тооцооны програм 15.5 сая төгрөг, зорлогын ажил, хөдөлгүүр ороолгох ажлуудын 6.2 сая төгрөг хэмнэсэн байна.

Туслах аж ахуйн зардал 5.3 сая төгрөгөөр хэтэрсэн боловч 42.9 сая төгрөгийн төгрөгийн орлого олж 30.2 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
Шатахууны зардал	0.4	0.3	-0.1
Хорогдсон мал	0	0.7	0.7
Өвс тэжээл	7.0	3.2	-3.8
Малын ББӨ	0	8.5	8.5
Зардлын дүн	7.4	12.7	5.3
Нас дэвшилт, ноолуур	10.5	4.9	-5.6
Мал борлуулсан	8.0	38.0	30.0
Орлогын дүн	18.5	42.9	24.4
Нийт ашиг	11.1	30.2	19.1

Зардлын гүйцэтгэл

№	Зардлын төрөл	2020.12.31	2021.12.31		2021 оны	
			төлөв	гүйц	төл-с	%
1	Цалин	1,250.3	1,307.2	1,026.0	(281.2)	78.5
2	НДШимтгэл	181.3	189.5	154.4	(35.1)	81.5
	ДҮН	1,294.6	1,431.5	1,496.8	1,180.4	(316.3)
3	Урсгал засвар	51.9	54.9	53.9	(1.1)	98.1
4	Хангамжийн материал	15.2	14.3	14.2	(0.0)	99.7
5	Туслах материал	7.5	7.7	7.5	(0.2)	97.8
6	Цахилгаан эрчим хүч	330.1	309.3	301.1	(8.2)	97.3
7	Дотоод хэрэгцээ	168.8	168.8	167.8	(1.0)	99.4
8	Нүүрс	563.1	601.0	587.3	(13.7)	97.7
9	ТУЗ-ийн зардал	67.5	69.4	67.8	(1.5)	97.8
10	Холбоо	5.7	7.4	6.5	(0.9)	87.9
11	Бичиг хэрэг	3.5	4.6	4.3	(0.3)	94.0
12	Албан томилолт	1.8	8.4	1.5	(6.9)	17.7
13	ҮХ-н элэгдэл	410.1	418.3	418.3	(0.1)	100.0
14	Хөдөлмөр хамгаалал	46.9	79.7	45.1	(34.6)	56.6
15	Шатахуун түлш, тос	49.6	49.2	46.0	(3.2)	93.6
16	Дээж шинжилгээ	0.9	1.5	0.8	(0.7)	50.5
17	ҮХХ-н татвар	6.6	7.5	6.6	(0.9)	0.0
18	Газрын татвар	0.4	1.7	0.4	(1.3)	22.3
19	АТӨЯХ-н татвар	0.8	0.9	0.8	(0.0)	0.0
20	Усны нөөц ашиг. татвар	1.5	1.9	1.7	(0.2)	0.0
21	Бусдаар гүйц. ажил	73.9	116.5	94.8	(21.7)	81.4
22	Нийгэм САХэмжээ	85.0	42.7	36.2	(6.5)	84.8
23	Сургалт	5.0	5.0	4.9	(0.0)	0.0
24	Хэвлэл захиалга	0.4	0.5	0.4	(0.1)	76.3
25	Сэлбэг хэрэгсэл	6.6	13.7	13.6	(0.2)	98.7
26	Гүйцэтгэх удирдлагын зардал	102.2	103.0	101.6	(1.4)	98.6
27	Байгаль орчны нөлөөлөл	2.5	3.0	2.5	(0.5)	0.0
28	Сүлжээний усны зардал	29.9	32.2	28.8	(3.3)	89.6
29	Зээлийн хүүгийн зардал	22.9	22.9	9.3	(13.6)	40.8
30	Туслах аж ахуйн зардал	7.5	7.4	12.7	5.3	172.0
	Нийт зардлын дүн	3,499.3	3,650.0	3,216.8	(433.2)	88.1

- АВЛАГА

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	өсөлт + бууралт -
Төсөв	0	72.0	72.0
ААНБ	198.6	193.6	-5.0
Айл өрх	68.2	43.4	-24.8
Засгийн газрын хөнгөлөлт	58.0	120.0	62.0
Дүн	324.8	429.0	104.2
Бусад авлага	4.7	4.7	0
НИЙТ ДҮН	329.5	433.7	104.2

Оны эхнээс нийт авлага 104.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

- Төсвийн байгууллагууд ЭХЗХ-ны 465 тоот тогтоолоор батлагдсан үнэ тарифыг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас 72.0 сая төгрөгийн авлага үүссэн.

- Засгийн газрын хөнгөлөлттэй холбогдуулан Байцаагч нарт сар бүр барагдуулах авлагын төлөвлөгөө гарган, цалин урамшууллыг уялдуулсан журмыг боловсруулан, үлдэгдэлтэй хэрэглэгч бүртэй төлөлтийн хуваарь гарган мөрдөн ажиллаж 29.8 сая төгрөгийн авлагыг барагдуулсан.

- Засгийн газраас айл өрх, зарим аж ахуйн нэгж байгууллагын ус, дулааны эрчим хүчний хөнгөлөлттэй холбоотой 120.0 сая төгрөг хугацаандаа орж ирээгүйгээс үүссэн.

2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшингийн төлөвлөгөөнд нийт авлагыг 110.5 сая төгрөг байхаар төлөвлөсөн боловч нүүрсний үнийн зөрүүнээс үүссэн 177.9 сая төгрөгийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган анхан болон давах шатны шүүхээс Шарын гол ХК-аар төлүүлэхээр шийдвэр гарсан боловч уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй учир Дээд шүүхэд гомдол гаргасан өнөөдрийг болтол шийдвэрлээгүй байна. Мөн засгийн газрын хөнгөлөлт 120.0 сая төгрөг ондоо багтаж орж ирээгүй зэргээс шалтгаалан 323.1 сая төгрөгийн авлага бууруулах боломжгүй байна.

- ӨГЛӨГ

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	өсөлт + бууралт -
Цахилгаан	438.5	398.6	-39.9
Татвар	543.3	649.8	106.5
НДШ	350.8	422.3	71.5
Бусад өглөг	452.1	348.9	-103.2
ДҮН	1,784.7	1,819.6	34.9

Нийт өр төлбөр оны эхнээс 34.9 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Татварын өглөг 106.5 сая төгрөг,
- НДШ-ийн өглөг 71.5 сая төгрөгөөр тус тус өсч
- Цахилгааны өглөг 39.9 сая төгрөг / тайлант онд 326.3 сая төгрөг төлсөн /
- Бусад өглөг 103.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Өглөг нэмэгдсэн шалтгаан нь Засгийн газрын хөнгөлөлт 120.0 сая төгрөг ондоо багтаж орж ирээгүйн улмаас мөнгөн хөрөнгийн дутагдалд орж өглөг нэмэгдэх үндэслэл үүссэн. Цаашид өр төлбөрийн судалгаа гарган, мөнгөн хөрөнгийн урсгалыг оновчтой тооцоолон, графикт төлөвлөгөө гарган барагдуулахаар ажиллаж байна.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор худалдан авах төлөвлөгөөг 435.2 сая төгрөгийн худалдан авалт хийхээр баталсан. Эрчим хүчний сайдын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/165 дугаар тушаалаар 377.1 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөгөөнд тодотгол хийсэн.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2 тендер зохион байгуулалтыг хуулийн дагуу зохион байуулсан.

- Түлш шатахуун, тослох материал худалдан авах 57,4 сая төгрөгийн худалдан авалтыг <https://www.tender.gov.mn/> цахимаар 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зарлаж 2 оролцогч санал ирүүлсэн хэдий ч тендерийн шалгуур үзүүлэлт хангаагүй тул тендерийг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр дахин зарласан. Тендерийг дахин зарлахад Халиун шарын гол ХХК оролцож тендерийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан тул тендерт шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

- Ус зөөлрүүлэх фильтр худалдан авах ажиллагааг тодотголоор 29,0 сая төгрөгийн төсөвтэй батлуулан хуулийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж, Гоулденрезин ХХК-тай гэрээ байгуулан 27,9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан.

Тендерийн материалын баримт бичгийн бүрдэл бүрэн, цахимаар тухай бүрт мэдээлж, үр дүнг нийтэлсэн.

2021 оны гүйцэтгэлээр 297,5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

III. ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЫН ТАЛААР.

Техник тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлийн ажлыг компанийн техникийн бодлогын баримт бичиг, техник тоног төхөөрөмжид хийсэн эрсдэлийн үнэлгээ, эрчим хүчний аудитын дүгнэлт, зөвлөмж зэргийг үндэслэл болгон үйлдвэрлэлийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, алдагдлыг бууруулах, үр ашигтай байх зорилтуудын хүрээнд үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн хэдийгээр өндөр байгаа ч хөрөнгө санхүүгийн боломжийг тооцоолон, хийгдэх ажлуудыг эрэмбэлэн зайлшгүй хийгдэх ажлуудыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 28 багц ажил хийхээр төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. Үүнд:

- ✓ Зохион байгуулалтын талаар 8 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн
- ✓ Техник тоног, төхөөрөмж ашиглалт засварын талаар 15 багц ажил төлөвлөсөн, гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сургалтын талаар 5 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн байна.

ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.

Монгол Улсын Эрчим Хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/25 дугаар тогтоолоор 2021 оны Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтаар 154.1 сая төгрөгийн 12 багц ажил хийгдэхээр төлөвлөгөөг батлуулсан. Ковид-19 цар тахал гарснаас шалтгаалан компанийн орлого буурсан. Үүнтэй холбогдуулан Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх санал оруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Эрчим хүчний сайдын 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А/164 дугаар тогтоолоор 104.7 сая төгрөгийн 9 багц ажил хийхээр тодотгон батлуулж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа.

- Их засвараар үйлдвэрийн бохир усны шугам шинэчлэх ажлыг төлөвлөн 100 хувь хийж гүйцэтгэсэн.
- ТЗБАХ-ээр 5 давхар 11-р байрны хэрэглээний халуун ус, хүйтэн усны тоолуур төвлөрүүлэлтийн ажил төлөвлөн 100% хийгдэж дууссан
- Хөрөнгө оруулалтаар 7 төрлийн тоног төхөөрөмж авахаар төлөвлөн 100 хувь худалдан авалт хийгдэж, ашиглалтад оруулсан.

Нийт ИЗ, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажилд **94,7** сая төгрөг зарцуулсан байна.

УРСГАЛ ЗАСВАР:

Зуух, туслах тоноглол, шугам сүлжээний урсгал засвараар 20 багц ажил хийхээр төлөвлөж, 53.8 сая төгрөг зарцуулан 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Компанийн 2021 оны ИЗ, ТЗБАХ, ХО-ын гүйцэтгэл

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Төлөвлөсөн хөрөнгө /мян.төг/	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Гүйцэтгэлийн хувь
1.Их засвар						
1	Үйлдвэрийн бохир усны шугам шинэчлэх	м/хос	240	19,905.6	19,836.7	100%
ДҮН				19,905.6	19,836.7	100%
2. Хөрөнгө оруулалтаар						
1	Утаа сорогч /У6-41-11-90С 18550м3 3168Па/	ком	1	9,000.0	8,497.6	100%
2	Гүний усны насос	ком	2	11,000.0	11,000.0	100%
3	Түлшний конвейерийн редуктор	ком	1	9,000.0	8,500.0	100%
4	Хүчилтөрөгч тодорхойлох багаж	ш	1	3,146.0	3,146.0	100%
5	Трансформатор /ТМГ12-40 6/0.4/	ком	2	6,500.0	5,100.0	100%
6	Бохирын насос	ком	1	9,500.0	4,074.1	100%
7	Ус зөөлрүүлэх төхөөрөмж	ком	1	29,000.0	27,940.0	100%
ДҮН				77,146	68,258.7	100%
3. ТЗБАХ						
1	5-н давхар 11-р байрны ХХУ, ХУ-ны тоолуур төвлөрүүлэлт хийх	багц	1	7,620.7	6,604.7	100%
ДҮН				7,620.70	6,604.7	100%
НИЙТ ДҮН				104,672.30	94,699.2	100%

Техникийн дэвшил, бүтээн байгуулалт, үр өгөөжийн талаар:


1. 2020 онд хийгдэж эхэлсэн ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгууд, өргөх станцыг шилэн кабельд холбон, алсын зайн хяналт удирдлагын SCADA системийг нэвтрүүлэн автоматжуулж, камержуулах ажил бүрэн хийгдэж дууссан. Ус хангамжийн объектуудыг теле механикжуулалтын системд шилжүүлснээр гүний худгууд өргөх станцын үйл ажиллагааг цаг тухайд нь тоон утгаар хянах, тэдгээрийг шаардлагатай үед ажиллуулах, зогсоох зэргээр алсаас удирдаж, гадна болон дотор камераар хянадаг болсон. Уг ажил ашиглалтад орсноор ажиллах хүчний зардал 90,2 сая төгрөгөөр буурах боломж бүрдсэн бөгөөд анхны хөрөнгө оруулалтаа 1.2 жилд эргэн төлөх тооцоо гарсан.



2. Эрчим хүчний аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэвэр усны II-р өргөх станцын 250 кВа хүчин чадалтай трансформаторын хүчин чадлыг бууруулж одоогийн хэрэглээнд тохирсон эрчим хүчний хэмнэлттэй 100 кВа трансформатороор шинэчилж сольсноор эрчим хүчний алдагдал буурсан. Хоосон явалтын горимоор тооцоход сард 5400 кВт цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарган ажилласан байна.



3. Сумын төв бохир усны насос станцын СД маягийн 37 кВт-ын хөдөлгүүртэй насосны хүчин чадлыг бууруулан эрчим хүчний хэмнэлттэй MJ -100/30 маркийн 22кВт-ын хөдөлгүүртэй насосоор шинэчлэн ашиглалтад оруулснаар ашиглалтын зардал буурч, цахилгаан эрчим хүчний хэрэглээ багасч, хэмнэлт гарах боломж бүрдсэн. Тайлант онд 2259 кВт цахилгаан эрчим хүч буюу 371.3 мянган төгрөгийн хэмнэлт гарсан. Цаашдаа жилд 3485 кВт цахилгаан эрчим хүч буюу 572.9 мянган төгрөгийн хэмнэлт гарах тооцоо гарч байна.



4. 5-н давхар 11 дүгээр байрны 2 дугаар узельд хэрэгцээний халуун хүйтэн усны босоо шугам шинэчлэн, усны тоолуур төвлөрүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг ажлыг жил бүр үе шаттайгаар хийж байгаа бөгөөд усны зөв зохистой хэрэглээг хангах, өр үүсгэхгүй байх, усны төлбөрөө төлөөгүй тохиолдолд бусад айл өрхөд хамааралгүй таслалт хийх, хэрэглээний халуун хүйтэн усны тоолуурын заалт авахад хялбар, хэрэглэгчийн босоо шугамын гэмтэл, хэрэглээний халуун ус халахгүй айлын холигчоор холилддог байдал бүрэн зогсож дуудлагын тоо буурсан зэрэг үр өгөөж гарч байна.



5. ДЗЛ маркийн 2-р зуухны утаа сорогчид эрчим хүчний хэмнэлттэй утаа сорогчийг худалдан авч ашиглалтанд оруулахаар бэлтгэл ажил хангасан, мөн усны эх үүсвэрийн гүний худгуудад 2 ширхэг гүний насос худалдан авч суурилуулсан бөгөөд

эдгээр тоног төхөөрөмж шинэчлэгдсэнээр сумын орон сууцны хэрэглэгчдийн ус, дулаан хангамжийн тасралтгүй найдвартай ажиллагаа сайжирсан.

2021 онд ИЗ, ТЗБАХ, ХО-аар хийгдсэн ажлын үр өгөөжийн тооцоо

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Төлөвлөгөөт ажлын үр дүн	Хэмнэлт /мян.төг/
1.Их засвар				
1	Үйлдвэрийн бохир усны шугам шинэчлэх	19,836.8	Үйлдвэрийн бохир ус татан зайлуулах найдвартай ажиллагаа хангагдсан	-
ДҮН		19,836.8		-
3. ТЗБАХ				
1	5-н давхар 11-р байрны ХХУ, ХУ-ны тоолуур төвлөрүүлэлт хийх	6,604.7	Усны зөв хэрэглээг хангах өр үүсгэхгүй байх нөхцөл бүрдүүлсэн. Айл өрх усны төлбөрөө төлөөгүй тохиолдолд бусад айл өрхөд хамааралгүй таслалт хийх боломжтой болсноор орлого төвлөрүүлэлт сайжирсан. Хэрэглээний халуун хүйтэн усны тоолуурын заалт авахад хялбар болох мөн хэрэглэгчийн босоо шугамын гэмтэл, ХХУ халахгүй айлын холигчоор холилдог байдал бүрэн зогсож дуудлагын тоо буурсан	-
ДҮН		6,604.70		-
2. Хөрөнгө оруулалтаар				
1	Утаа сорогч /У6-41-11-90С 18550м3 3168Па/	8,497.6	Утаа сорогчийг суурилуулснаар зуухны найдвартай ажиллагаа хангагдахаас гадна цахилгаан эрчим хүчний хэмнэлт сард 7020 кВт гарах урьдчилсан тооцоо гарсан.	1,153.9
2	Гүний усны насос	11,000.0	Гүний усны насос суурилууснаар сумын айл өрх, аж ахуй нэгж, төсвийн байгууллагуудын унд, ахуйн ус хангамжийн найдвартай ажиллагаа сайжирсан.	-
3	Түлшний конвейерийн редуктор	8,500.0	Түлшний 212-р туузан дамжуулгын редукторыг шинэчилснээр тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа сайжирсан	-
4	Хүчилтөрөгч тодорхойлох багаж	3,146.0	2018 онд Дулааны станцын ус бэлтгэлд ус хийгүүжүүлэх төхөөрөмж /төмрийн үртсэн деаэратор/-ийг шинээр суурилуулж ашиглалтад оруулсан. Хийгүүжүүлэлт автоматаар явагддаг. Хийгүүжүүлэлтийн үр дүнгийн шинжилгээг, харьцуулалтын аргаар хийдэг байсан бөгөөд уг багажийг авснаар шинжилгээний үр дүн сайжирч бодитоор тодорхойлдог болсон.	-
5	Трансформатор /ТМГ12-40 6/0.4/	5,100.0	Эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу цэвэр усны II-р өргөх станцын 250 кВа хүчин чадалтай трансформаторыг хэрэглээнд тохирсон 100 кВа-н эрчим хүчний хэмнэлттэй трансформатороор шинэчилж сольсноор эрчим хүчний алдагдал буурсан. Хоосон явалтын горимоор тооцоход сард 5400 кВт цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарган ажилласан.	887.65
6	Бохирын насос	4,074.1	Тосгоны төв бохир усны станцын СД-160/45 маркын 1-р насосны хүчин чадлыг бууруулан MJ -100/30 маркийн насос шинээр суурилуулж, ашиглалтад оруулснаар бохир ус татан зайлуулах үйл ажиллагааны найдвартай байдал сайжирсан. Мөн цахилгаан эрчим	371.33

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

			хүчний хэмнэлт гарган ажиллаж байна. насосны цахилгааны эрчим хүчний хэмнэлтийг тооцоход 10,11,12 сард нийт 2259 кВт цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарсан.	
7	Ус зөөлрүүлэх төхөөрөмж	27,940.0	Ус зөөлрүүлэх цахилгаан фильтрийг суурилуулснаар сүлжээний усны хатуулгыг стандарт хэмжээнд бууруулах, ажиллах зарчмын хувьд хялбар бөгөөд давсны зарцуулалт багассан.	-
ДҮН		68,258.0		2,412.88
НИЙТ ДҮН		94,699.2		2,412.88

IV.ХАБЭА, АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТАЛААР ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

- Төлөвлөгөөт гал эсэргүүцэх, аваар эсэргүүцэх, осол эсэргүүцэх дасгалууд, зааварчилгааны биелэлтийн мэдээ болон ХАБЭА-н ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Эрчим хүчний яамны сайтад 7 хоног тутам байршуулсан.

- Нэгдсэн дүнгээр I шатны үзлэгийг давхардсан тоогоор 356 удаа хийж 213 зөрчил, II шатны үзлэгийг 162 удаа хийж 268 зөрчил, III шатны үзлэгийг 2 удаа хийж 44 зөрчил илэрснийг холбогдох ажилтнуудад зөрчил арилгуулах талаар хугацаат албан даалгавар өгч, биелэлтийг хангуулан ажилласан.



- Системийн хэмжээнд гарсан үйлдвэрийн осол, технологийн зөрчлийн талаар дээд шатны байгууллагаас ирүүлсэн сэрэмжлүүлэх, мэдээлэл даалгавар тухай бүрт компанийн нэгдсэн төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах, тогтоосон хугацаанд мэдээлэл даалгаврын хариуг хүргүүлэх ажлыг тухай бүр хийж гүйцэтгэлээ.

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ ТАЛААР

Компанийн ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл ахуйг хангах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрмийн заалтуудыг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд компанийн гүйцэтгэх захирлын 2012 оны 03 сарын 15-ны өдрийн 29 дүгээр тушаалаар батлагдсан “Ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүний норм тогтоох, олгох, ашиглах, хадгалах тухай” журмыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, ХАБЭА-н Үндэсний хорооны "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох зөвлөмж батлах тухай" 2021 оны 08 сарын 10-ны өдрийн 23 тоот тогтоолын дагуу шинэчлэх ажлыг зохион байгуулж, 2022 оноос эхлэн мөрдөж ажиллаж байна.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилгоор ХАБЭА-н тухай хууль холбогдох аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрэм журамд үндэслэн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалтын болон удирдлагын нэгдсэн журам”, “Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн зааварчилгаа” Ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн заавар” зэргийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллалаа.

- Ажлын байруудын орчны температур, агаарын чийгшил, дуу чимээ, гэрэлтүүлгийн хэмжээг зориулалтын багажаар сар бүр хэмжин, дүгнэлт гарган ажилласан.

- Эрүүл мэндийн сайдын 340-р тогтоолын дагуу ХАБЭА Мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй үзлэгийн баг 2021 оны 09 сарын 18-20-ны өдрүүдэд ажилтнуудын эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээг биохими / асат, алат, билирубин /, цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, Н Pylori эсрэг биетийн шинжилгээ, В вирусийн шинжилгээ, С вирусийн шинжилгээ, БЗХӨ /тэмбүү/-ийн эсрэг биетийн шинжилгээ, хордлогын эсийн шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг, спиро, хэвлийн ЭХО, цээжний рентгэн зураг, сонсголын бичлэг гэсэн төрлөөр цогц байдлаар эрүүл мэндийн хугацаат ээлжит үзлэгийг компанийн ажлын байранд хийлээ.

- Ажилтнуудын дунд тохиолдож буй ердийн болон мэргэжлийн өвчнийг илрүүлэн оношлож, ажилтан гүйцэтгэж буй ажил мэргэжилдээ эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхэд мэргэжлийн тохироог хийж, цаашид эрүүл мэндийг хэрхэн хянах, эрүүлжүүлэх ажлын талаар заавар зөвлөмжүүдийг өгч ажилласан.

- Нийт хамрагдвал зохих 87 ажилтнаас үзлэгээр 70 хүн ба 80.4% үүнээс эрэгтэй 35 хүн 50%, эмэгтэй 35 хүн ба 50%, үзлэгт хамрагдсанаас эрүүл ажилтан 14, давхардсан тоогоор нийт 107 өвчлөл бүртгэгдсэн байна.



ГАЛЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТАЛААР

2021 онд галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Ковид-19 цар тахал болон галын аюулгүй байдал гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд компанийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний гамшгийн үед дайчлагдах мэргэжлийн анги болон цар тахлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тухай бүр тодотгол хийж сум орон нутгаас зохион байгуулсан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг болон эргүүл үзлэг шалгалтад тухай бүр мэргэжлийн анги бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон.

- Ажлын байранд галын аюулгүй байдлыг хангуулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

- Онцгой байдлын Гал унтраах 55-р ангийн бие бүрэлдэхүүнтэй хамтарч “Компанийн байр болон гадна орчинд гал гарсан үед ажиллах” “Галын хортой хэрхэн ажиллах болон гал гарч байгаа үед хэрхэн унтраах” сэдвээр хөтөлбөр гарган компанийн хэмжээнд “Гал эсэргүүцэх дасгал”-ыг явуулах ажлыг танхимын болон практикаар талбайд үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор нийт 86 ажилтан хамрагдсан.



- Ажлын байруудын галын булангийн иж бүрдэлтэд хяналт тавьж, дутууг гүйцээх, галын хор ажлын байруудад байрлуулах

- Ажлын байруудын галын булангийн иж бүрдэлтэд хяналт тавьж, дутууг гүйцээх, галын хор ажлын байруудад байрлуулах ажлын хүрээнд нийт ажлын байрны цэнэг дууссан галын хорнуудыг “Гал импекс”ХХК-р дахин цэнэглүүлж 126,000 төгрөгийн зардал гарсан.

- 4кг-ын савалгаатай автомат галын хорнуудыг ус түгээх нийт найман худагт 576,000 төгрөгийн галын хор тавьж, галын хяналтын карт хөтлөн хяналт тавьж ажиллаж байна



- УДАТХэсгийн галын булангын эсгийнүүд эрвээхэйд идэгдсэн шаардлага хангахгүй болсон “галын хөнжил” шинээр 125,000 төгрөгөөр авч байрлуулан иж бүрдлийг гүйцээсэн.



- 2021 онд ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан нийт 8 ажлын байрны галын дүгнэлтийг сунгуулах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Онцгой байдлын Газрын галын улсын байцаагчтай хамтран галын аюулгүй байдалд үзлэг шалгалт хийж галын дүгнэлт болон зөвшөөрлийг сунгасан.

- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний хуулийн хугацаа дууссаныг тодотгох ажлыг “Евро - Ази” ХХК-аар төлөвлөсөний дагуу хийлгэж байна.

- Хавар намрын хуурайшилтын үед нийт ажилтнуудад ээлжит бус зааварчилгааг өгч ажилласан. Сумын ЗДТГазраас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Шарын гол сумын эргэн тойронд Хар ямаат, Буурт, Санжинт, Буянт зэрэг газруудаар компанийн инженер техникийн ажилтнууд графикайн дагуу нийт 7 хоног хяналт шалгалт хийсэн ба хяналт шалгалтаар дэгдсэн түймэр болон зөрчил байхгүй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР

Байгаль орчинг хамгаалах чиглэлээр дараах чиглэлийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- ХӨРС

Дархан-Уул аймгийн Ус цаг уур орчны лабораторитой хийсэн гэрээний дагуу "Дулааны станц, цэвэрлэх байгууламж, КНС-н орчмын хөрсөнд Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн "Байгаль орчны шинжилгээний лабораторид хяналт шинжилгээг хагас жилд нэг удаа байхаар төлөвлөн , сорьц авч шинжлүүлэн, хариу гаргуулан ажиллалаа.

Хөрсний 2 удаагийн шинжилгээгээр хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт бохирдлыг үнэлэх MNS3297-2019 стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын үзүүлэлт нитрат /NO₃ /, сульфат /SO₄ /- ын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй буюу байгаль орчинд сөрөг үр дагавар гараагүй болно.

2022 оны улирлын шинжилгээгээр ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартаар эх үүсвэрийн болон төвлөрсөн сүлжээний ус түгээх худгийн ус нь МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторийн дүнгээр шаардлага хангасан үзүүлэлтүүдтэй байна.



Компанийн чацарганы төгөлөөс 219 кг чацаргана жимсийг хураан авч, хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтнуудад хор саармагжуулах болгон олгосон.



V. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Ковид-19 цар тахлын эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд

- Компанийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлан үйлдвэрлэлийн хэвийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт аюулгүй ажиллагаа, ажлын байрны аюулгүй байдалд үзлэг шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчлийг устгах, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байр хооронд онцын шаардлагагүй тохиолдолд сэлгүүцэхгүй байх талаар ээлжит бус зааварчилгааг өгч, тухай бүрт хэрэгжилтийг хангасан.

- Ариутгал халдваргүйжүүлэлт, хамгаалах хэрэгслийн нөөцийг дараах байдлаар бүрдүүллээ.

№	Бодисын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Мөнгөн дүн
1	Хлорамин	кг	150	750.000
2	Санитол	л	20	240.000
3	Жавелион	хайрцаг	5	359.400
4	Автомакс	ш	2	88.000
5	Халуун хэмжигч	ш	2	50.000
6	Резинэн бээлий	Хайрцаг	30	150.000
7	Маск /1 удаа/	ш	100000	400.000
8	Комбинзон	ш	100	500.000
9	Нэг удаагийн улавч	боодол	5	12500
10	Нэг удаагийн малгай	ш	2500	125000
11	Ковид-19 тест	ш	100	
Нийт дүн				2 674 900

Компанийн хэмжээнд Ковид-19 –ын вакцины 1, 2, 3-р тунд ажилтнууд 100 хувь хамрагдсан. 4-р тунд 4 ажилтан хамрагдсан байна.



- Ус түгээх худгуудын ариутгал халдваргүйжүүлэлт, ялангуяа хүний гар их хүрдэг хэсгүүд, ус түгээх хоолойг хуваарийн дагуу гүйцэтгэж, хэрэглэгчдэд эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэм барьж ,өөрийгөө болон бусдыгаа эрсдэлд оруулахгүй байх талаар санамж плакатуудыг байршуулсан.



- Компанийн хэрэглэгч олноор орж ирдэг, хэрэглэгчидтэй их харьцдаг өндөр эрсдэлтэй ажлын байруудад ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулсан.



- Суманд гэрийн тусгаарлалтад байгаа айл өрхүүдэд халдвар хамгааллын дэглэм баримтлан ундны ус түгээх ажлыг зохион байгуулж ажилласан.



- Суманд гэрийн тусгаарлалтад байгаа айл өрхүүдэд хяналт тавих ажлыг 1-3 дугаар сарыг дуустал батлагдсан хуваарийн дагуу халдвар хамгааллын дэглэм баримтлан хийж гүйцэтгэсэн.




- Цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Шивэртэд хяналтын хөдөлгөөнт эргүүлийн постыг зохион байгуулж ажиллан, батлагдсан хуваарийн дагуу 24 цагаар тасралтгүй хяналт тавих ажлыг 14 хоногийн хугацаанд ИТА нар хийж гүйцэтгэлээ.

VI. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН ТАЛААР :

“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол улсын засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2, 1.3 дахь заалтын хэрэгжилтийг хангаж батлагдсан 108 орон тоотой ажиллахаас шинээр албан тушаал бий болгохгүйгээр, сул орон тоо болон тэтгэвэр тогтоолгох нөхцөл бүрдэж тэтгэвэрт гарсан ажилтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийлгүйгээр 90 ажилтантай үйл ажиллагаагаа хэвийн найдвартай зохион байгуулж ажилласан. Байгууллагын хүний нөөцийг нөхөн бүрдүүлэх чиглэлээр нэн шаардлагатай ажлын байруудыг нээлттэй ажлын байрны зарыг байгууллагын цахим сүлжээнд тухай бүр нь байршуулж ажилласан. 2021 онд 8 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, 18 ажилтантай хөдөлмөрийн гэрээг цуцалснаас өөрийн хүсэлтээр 15, сахилгын шийтгэлээр 1, өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн 2, ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж, 7 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дуусгавар болгох, батлагдсан цалингийн санд багтаан ажилтнуудын цалинг тооцон, олгож байна.

Тус хугацаанд нийт ажилтнуудын хувийн хэргийн хавтсыг шинэчлэн, ажилтан тус бүр дээр хувийн хэргийн хавтас нээн, баяжилтыг тухай бүр хийж, програмд баяжуулалт хийх ажлыг зохион байгуулан ажилласан.

Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт (тариф)-ын хэлэлцээр батлагдсантай холбоотойгоор компанийн ажилтнуудын сарын үйл ажиллагааны нэмэгдэл хөлс болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журмыг шинэчлэн боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна.




СУРГАЛТЫН ТАЛААР

2021 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтуудыг “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор цахимаар болон танхимаар явууллаа. 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 9 сургалт төлөвлөснөөс 7 сургалтад давхардсан тоогоор 328 ажилтан хамрагдаж 4,080,000 төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан.


Дээд шатны болон холбогдох байгууллага, яам агентлагаас зохион байгуулсан цахим болон танхимын 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 25 ажилтан хамрагдсан байна.

Сургалтын төлөвлөгөөний дагуу компанийн нийт ажилтнуудын сургалтуудыг “classroom” ашиглан 100 хувь цахимаар явуулсан. Тус сургалтад давхардсан тоогоор 303 ажилтан хамрагдсан байна. ААД, ТАД-ын ээлжит сургалтыг 2021 оны 08 дугаар сараас эхлэн ИТА нарт болон үндсэн үйлдвэрлэлийн ажилтнуудад цахим “classroom болон telegram”-аар хичээлүүдийг оруулж, ААД, ТАД-ийн анхан болон ээлжит, давтан шалгалтад 131 ажилтан хамрагдаж мэргэжлийн ур чадварыг үнэллээ. Мөн мэргэжлийн зэрэг ахиулах шалгалтын төлөвлөгөө гарган шалгалтын комиссын бүрэлдэхүүнтэй хамтран зохион байгуулж, нийт 14 ажилтан хамрагдсан ба 1 ажилтан хангалтгүй үнэлгээ авч, 13 ажилтан тэнцэж, зэрэг ахиулсан байна.


Мэдлэгийн шалгалтын тестүүд боловсруулж, ерөнхий инженерээр хянуулан, хүний нөөцийн програмд 120 тестийг шинээр шивж оруулсан.



Улаанбаатар хотод болсон “Эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэл”-ээс зохион байгуулагдсан “Хөдөлмөрийн тухай шинэчилсэн найруулга” сэдэвт 2 өдрийн сургалт



ИТА-уудад зориулсан "Удирдах ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадварыг сайжруулах" сэдэвт цахим сургалт



ИТА-уудад зориулсан "Удирдах ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадварыг сайжруулах" сэдэвт цахим сургалт



"Усны тоолуурын шалгалт, баталгаажуулалт" сэдэвт цахим сургалт



"Химийн бодисын аюулгүй байдал, хүрээлэн буй орчин" сэдэвт онлайн сургалтад Химич К.Анаргуль амжилттай хамрагдаж, уг сургалтаар 4 лаборантуудад сургалт зохион байгуулсан нь



Даралтад савны эрх авах, сунгах сургалт

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан сумынхаа 2 дугаар сургууль болон 6 дугаар сургуулийн 6-8 дугаар ангийн 96 сурагчдад **"Усны үнэлэмж, Үнэ цэнэ"** сэдэвт сургалтыг явуулсан. Мөн сумын Од кабелийн телевизээр 6 төрлийн шторкуудыг цацсан ба цахим орчинд шторк, мэдээллийг байршуулан ажилласан.



VII. ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР :

2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр “Дотоод хяналтын нэгжийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г гүйцэтгэх захирлаар батлуулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дотоод хяналт шалгалтыг 5 бүлэг, 33 чиглэлийн хүрээнд зохион байгуулсан. Дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх захирлын байгуулсан ажлын хэсэг болон дотоод хяналтын ажилтан хийж гүйцэтгэн үр дүнг тухай бүр гүйцэтгэх захиралд танилцуулан, захирлын зөвлөлийн хуралд 2 удаа танилцуулсан. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан.

Хууль тогтоомжууд болон компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд 4 чиглэлээр хяналт тавьж, 6 зөвлөмж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд 8 чиглэлээр хяналт тавьж, 3 зөвлөмж, санхүүгийн үйл ажиллагаанд 10 чиглэлээр хяналт тавьж, 7 зөвлөмж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд 10 чиглэлээр хяналт тавьж, 2 зөвлөмж, байгаль орчны нөхөн сэргээлтэд 4 чиглэлээр хяналт тавьж 1 зөвлөмж, Бусад чиглэлээр 2 зөвлөмж, нийт 21 зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Тайлан нэгтгэсэн:

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Д.Урангуа